БАТЛАВ
БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Б.НАРАНГЭРЭЛ

2024 оны .... дугаар сарын ....

9023090504
9088822 СБТ23067

# "ГАДНА ТАЛБАЙН АВТО ЗОГСООЛ ШИНЭЧЛЭХ" (27 ДУГААР ХОРОО) АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 1.. дугаар сарын .23 Дугаар 24/20 Улаанбаатар хот

| | | |
|---|---|---|
| 1 | Ажил гүйцэтгэх үндэслэл | - Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 24 дүгээр тогтоол<br>- Баянгол дүүргийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/16 дугаар захирамж |
| 2 | Байршил | - БГД, 27 дугаар хороо, Хүүхдийн ордны гадна талбайд авто зогсоол шинэчлэх |
| 3 | Төсөл боловсруулах үе шат | 2 үе шаттай.<br>1. Ажлын зураг, төсөв боловсруулж магадлал хийлгэх<br>2. Батлагдсан зураг төсвийн дагуу тохижилтын ажлыг гүйцэтгэж, хүлээлгэн өгөх |
| 4 | Төсөл гүйцэтгэх хугацаа | - Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно. |
| 5 | Төсөл боловсруулах байгууллага | - Холбогдох тусгай зөвшөөрөлтэй ,эрх бүхий байгууллага |
| 6 | Хөрөнгө оруулагч (захиалагч) байгууллага | - Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар |
| 7 | Төлөвлөлтөнд тавигдах шаардлага | Ерөнхий шаардлага:<br>- Холбогдох стандарт нормуудыг хангасан зураг төсөв боловсруулах |
| 8 | Онцгой нөхцөл | - Орц гарцыг замын хөдөлгөөний урсгалтай зөв уялдуулсан байх<br>- Одоо ашиглаж байгаа авто замын засвар шинэчлэлтийн зураг төслийг боловсруулахдаа замын хучилт, явган замын хучилт, авто замын хашлага болон явган хүний замын хашлага солих, хөдөлгөөн зохион байгуулалтыг сайжруулахын тулд үндсэн замын хийц болон геометр хэмжээсийг өөрчлөлгүйгээр төлөвлөх<br>- Авто замын төлөвлөлтийн шатанд буюу авто замын дэвсгэр зургийг захиалагчтай зөвшилцөж санал авсны үндсэн дээр зураг төслийг боловсруулж тоо хэмжээг гаргах<br>- Тухайн ажлын тоо хэмжээг гаргаж төсөв бодон, төсвийг магадлалаар хянуулах<br>- Тухайн орчинд хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хийгдэж байгаа тохижилтын болон инженерийн зураг төсөлтэй |

| | | |
|---|---|---|
| | | тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд төлөвлөх, гүйцэтгэх;<br>- Зам талбай нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шаардлагыг бүрэн хангасан байх;<br>- Гэрэлтүүлгийн шон /нарны эрчим хүчээр шийдвэрлэх боломжийг судлан, төлөвлөх/, хайс нь явган хүний замд саад учруулахгүй байх;<br>- Ажлын зурагт бусад инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийг нэг дэвсгэр дээр нэптэн, хоорондын зайн хэмжээг огтлолын зургаар тодорхой үзүүлж, норм стандартын дагуу төлөвлөх;<br>- Авто замын нэвтрэх хэсэгт төлөвлөсөн инженерийн шугам сүлжээний хонгилын системтэй уялдуулах;<br>- Зураг төслийн ажлыг гүйцэтгэхдээ дүүрэг, ашиглагч байгууллагатай газар дээр нь зөвшилцөж, гүйцэтгэх;<br>- Инженерийн шугам сүлжээний техникийн нөхцөлийн дагуу газар доорх шугам сүлжээг тодруулсны үндсэн дээр зураг төслийг боловсруулах |
| 9 | Барилгын үндсэн бүтэц, материал | - Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дотоодын болон олон улсын стандартын шаардлагад нийцсэн материал байх |
| 10 | Зураг төсөл боловсруулахад ашиглах материал | Монгол Улсын хуулиуд:<br>- Хот байгуулалтын тухай, Барилгын тухай хууль болон бусад холбогдох хуулиуд<br>Бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүд:<br>- Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага<br>Стандарт, норм дүрэм:<br>- Хашаа, хайс, хашлага /UCS 1410B /<br>- Гэрэлтүүлэх төхөөрөмж байрлуулах, суурилуулах технологийн удирдамж / UCS 1902A /<br>- Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байршуулах хогийн саванд тавих шаардлага UCS 1406B<br>- Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага UCS 0901B<br>- Гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага UCS 1901B<br>- Мод таримал ургамлын төрөл зүйлийн лавлах UCS 0802C<br>- Хот суурин газрын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөлт / UCS 0801A:2020 /<br>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНбД 30-01-04/<br>- Барилга орчны тохижилтын ажил /БНбД 3,01,06-90/<br>- Авто зам төсөллөх/ЗЗБНбД 22-004-2016/;<br>- Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм /БНбД 21-02-02/;<br>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНбД 30-10-04/;<br>- Цахилгаан тоног төхөөрөмжийн байгууламжийн дүрэм /БД 43-101-03/;<br>- Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг /БНбД 23-02-08/; |

| | | |
|---|---|---|
| | | - Барилгын төсөв зохиох дүрэм /БНбД 81-95-12*2020/;<br>- ХАБЭА-н норм, нормативын баримт бичгийг мөрдөж ажиллах;<br>- Бусад хот байгуулалт, барилга байгууламж, тохижилт, гэрэлтүүлэг, авто замын норматив баримт бичиг, норм, дүрэм, заавар, стандарт. |
| 11 | Төслийн иж бүрдэл | - Одоогийн байдлын судалгаа<br>- Ажлын зураг<br>- Нэгдсэн төсөв<br>- Магадлалын ерөнхий дүгнэлт<br>Бусад холбогдох материалууд |
| 12 | Эдийн засгийн тооцоо, төсөв | - Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох. |

ХЯНАСАН
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА Г.МӨНХ-ЭРДЭНЭ

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Г.ЭНХЦЭНГЭЛ

БОЛОВСРУУЛСАН
ТНААХ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.НЯМСҮРЭН




Таних тэмдэг

Төлөвлөж буй талбай

| Газрын байршил | Газрын зориулалт |
| --- | --- |
| Баянгол дүүрэг, 27 дугаар хороо, Хүүхдийн ордны орчмын авто зогсоол | Авто зогсоол |